

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 11 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 255

Улаанбаатар хот

“Арвижих хас” хоршоонд хадгаламж зээлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.4, Хоршооны тухай хуулийн 48¹.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Арвижих хас” хоршоонд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Арвижих хас” хадгаламж, зээлийн хоршоо /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал /-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ